

Хувь хүний орлогын албан татварыг боловсронгуй болгох нь

Ч.Цэндмаа

Татварын ерөнхий газар

1. Хувийн хүний орлогын албан татварын өөрчлөлт, шинэчлэлийн олон улсын чиг хандлага, туршлага
2. Монгол Улсын Хувь хүний орлогын албан татварын өнөөгийн төлөв байдал
3. Хувь хүний орлогын албан татварын талаарх шийдвэрлэх асуудлууд, хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Хувийн хүний орлогын албан татварын өөрчлөлт, шинэчлэлийн олон улсын чиг хандлага, туршлага

Дэлхийн олон улс оронд хувийн орлогын татварын систем нь өөрчлөн шинэчлэгдсээр ирсэн боловч хамгийн төгс гэх гүйцэд боловсронгуй загвар өнөөг хүртэл бий болоогүй байна.

Өрнөж буй шинэчлэлүүд нь:

- Улс орны хүрээнд хөрөнгө оруулалт, хуримтлалыг урамшуулах;
- Ажиллах, өдөлмөрлөх, бизнес эрхлэлтийг дэмжсэн таатай орчинг бүрдүүлэх;
- Улс хоорондын харьцааны үүшинд гадаадын хөрөнгө оруулалт, шинэ технологи, ухаалаг хүний нөөцийг өөртөө татсан санхүүгийн өрсөлдөөнт орчин боломжийг бий болгоход чиглэгдэж байна.

Хувийн орлогын татвараар төрийн төсвийн орлогыг бүрдүүлэн, орлогыг дахин хуваарилж, улс орны улс өр, эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах чухал хэрэгсэл болгохын сацуу уг татварын шударга (fairness), энгийн ойлгомжтой (simplicity), үр ашигтай (efficiency) байх гэдэг зарчмуудыг хангах явдал татварын шинэчлэлийн гол зорилго байсаар байна.

Шударга байх зарчим нь адил нөхцөлд байгаа хүмүүсээс адил хэмжээний татвар авч, татварын ачааллыг тэгш хуваарилахыг;

Энгийн байх зарчим нь татвар өлөх явц татвар өлөгчид зовиур дарамтгүй, татвар хураалгах, хураалтын зардал аль болох бага байлгахыг;

Үр ашигтай байх зарчим нь хувийн орлогын татварын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл болох татвар төлөхөөс төлөхгүйг, ажиллахаас амралт чөлөөт цагийг, хуримтлуулж хөрөнгө оруулахаас хэрэглэхийг илүүд эрхэмлэх татварын гажуудлыг аль болох бага байлгахыг тус тус шаардаж байна.

Татварын шинэчлэлийн ихэнх хэсэг нь татварын хувь хэмжээг бууруулан, татварын бааз суурийг өргөтгөх явдал юм.

Үүний тулд хувийн орлогын бүх төрлийг татварын суурьт бүрэн хамруулах, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг багасган сууриа өргөтгөх, татварын тогтмол нэг


хувь хэмжээ хэрэглэх, татварын дээд хязгаарыг бууруулах зэрэг чиг хандлагууд зонхилж байна.

Олонхи улс орон орлогын бүх төрөлд адил хэрэглэгддэг өсөн нэмэгдэх шатлалтай нийтлэг хувь хэмжээт хувийн орлогын татварын системээс (comprehensive personal income tax system) хөндийрч, орлогын нэрээр дутуулсан тусгайлсан хувь хэмжээ хэрэглэдэг хосолмол орлогын татварын систем (dual income tax system), нэг хувь хэмжээт тогтмол татварын систем (flat tax) руу шилжиж байна.

Тогтмол (flat tax) татварын асуудал улэрт чдийн анхаарал татсан сэдэв болоод байна.


Улс орон үрт хувийн орлогын татвар татварын нийт орлогод болон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийн жингийн хэмжээ харьцангуй өөр өөр түвшинд байна.

График 1. ЭЗХАХБ-ын орнуудын татварын нийт орлого болон дотоодын нийт бүтээгдэхүүнд хувь хүний орлогын татварын эзлэх хувь



Жишээ нь: ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын түвшинд 2005 оны байдлаар авч үзэхэд: хувийн орлогын татвар нийт татварын орлогод эзлэх хувь Словак улсад 11%, Солонгост 12,7% байхад Шинэ Зеландад 42%, Данид 53% хүртэл байна. Харин дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх жингээр Солонгос улс 3,2 %, Словак улс 3,3% -тай байхад Шведэд 15,8%, Данид улсад 25% -ийг тус тус эзэлж зөрүүтэй байгаа нь улс орон бүрийн хувийн орлогын алба н татварын ялгавартай бодлогыг дүнг илтгэн харуулж байна. Улс орны эдийн засгийн өсөлт хангагдан хөгжлийн түвшин дээшлэх тусам хувийн орлогын татварын хэмжээ өсч байдаг нь зүйн үзэгдэл бөгөөд хөгжиж буй оронд уг татварын эзлэх хувь бага байдаг нь хөдөлмөр, бизнес эрхлэх орчин муу хөгжсөн, ажилгүйдэл, ядуурал газар авсан, татвар өлөх нийгмийн боловсрол, төлөвшил муу, бүртгэл тооцоо сул хөгжсөн, татварын албаны чадамж сул, хууль тогтоомж нь боловсронгуй бус байдагтай шууд холбоотой байдаг байна.

График 2. ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын хувь хүний орлогын албан татварын хувь хэмжээ



Дээрхи графикаас харахад ЭЗХАХБ-ын гишүүн 19 оронд татварын хувь хэмжээ доошилж, хөдөлмөр эрхлэлтийн орлогод хэрэглэдэг татварын дээд хувь хэмжээний дундаж 3,71% -иар бууран, 2000 онд 47% байсан бол 2005 онд 43,3% болж, ногдол ашгийн орлогод ногдуулж байсан татварын дээд хувь хэмжээний дундаж 2000 онд 49,8%- байсан бол 2005 онд 44,5% болж өөрчлөгдөн орлогын түвшин бiрт хэрэглэж байсан татварын хувь хэмжээ буурч, татварын шатлалын тоо өөрсөн байдал тус тус ажиглагдаж байна.

Хувийн орлогын татварын бодлогын гол зорилго нь төсөв бүрдүүлэх, орлого, баялгийг дахин хуваарилах боловч сүүлийн үед ижил нөхцөл байдалд байгаа татвар төлөгч адил татвар төлнө гэсэн хэвтээ чиглэлийн шударга байдлыг хангах, татварын нөлөөллөөр үүссэн өрөг гажуудлыг багасгахыг эрмэлзсэн татварын өргөн бааз, жигд хувь хэмжээ ашигласан үр ашигт татварын зарчмыг баримтлах явдал ихээхэн анхаарлын төвд байх боллоо.

1.1 Хувь хүний орлогын албан татварын шинэчлэлд давамгайлж буй чиглэл хандлагууд, түүний хэрэгжилт ба туршлагауд

1.1.1 Нийтлэг буюу үбдийг хамарсан орлогын татварын систем (comprehensive personal income tax system)

Энэ нь цалин хөлс, хөдөлмөр эрхлэлт болон хөрөнгийн орлого зэрэг хувийн орлогын олон өрлийг нэгтгэн дунд нь өсөн нэмэгдэх нийтлэг хувь хэмжээг ашиглан татвар ногдуулдаг арга бөгөөд орлогын хэмжээ өсөх тутам эдлэх татварын хасалт, чөлөөлөлт нь өсч байдаг байна.

Давуу тал нь: Нийтлэг системийн үед татварын шударга болон үр ашигтай байх зарчим сайн хангагддаг гэж тооцдог. Учир нь хүний бүх орлогын нийлбэр нь түүний татвар төлөх чадварыг бүрэн илэрхийлнэ хэмээн үзэж, ижил орлоготой хүмүүс ижил татвар төлөх, нөгөө нь өндөр орлоготой татвар төлөгч илүү татвар төлөх ёстой гэсэн татварын хэвтээ болон босоо чиглэлийн шударга байх зарчмыг хэрэгжүүлдэг.

Хувийн **орлогын бүх төрөлд** адил татвар ногдуулснаар ялгаваргүй жигд хандаж, татварын нөлөөллийг бүгдэд адил мэдрүүлж, саармагжуулан, орлогын эх үүсвэрийг илүүтэй ашиг олох үйл ажиллагааны төрлүүдэд байршуулах хүмүүсийн

сонголт, шийдвэрт татварын нөлөөлөл үүсгэн эвддэггүй байна. Энэ систем нь ямар эх үүсвэрээс орлого орж байгаагаас үл хамаара н бүх орлогыг нэгтгэж , өсөн нэмэгдэх хувь хэмжээгээр татварыг тооцон авч байгаагаараа орлого дахин хуваарилах чухал хэрэгсэл болдог.

Сул тал нь: Энэ системийнүед өндөр татвартай орлогоос бага татвартай орлогын нэр өрлийн хооронд орлогоо шилжүүлж татвараас зугатах явдал бага гардаг ч, хууль хэрэгжүүлэх татвар хураалгах, хураах захиргааны зардал, өртөг их хэмжээгээр шаарддаг байна. Ялангуяа хөгжиж байгаа орнуудад татварын албадын татвар төлөгчдөө хянах, татварт хамруулах чадвар, чадамж доогуур байдаг нь энэ системийг авч хэрэглэхэд ихээхэн бэрхшээл учруулдаг. Мөн хүний орлого олж байгаа эх үүсвэрийн шинж байдлыг үл харгалзан хөрөнгө, орлогод хослуулан ижил татвар ногдуулахыг буруу хэмээн үүмжилж, х өрөнгийн орлого, хөдөлмөрийн орлогод тус тусад нь татвар ногдуулах ёстой гэсэн маргаан ч байнгын гарч байдаг.

Практикт нийтлэг орлогын татварын системийг дангаар нь бүрэн бүтэн хэрэгжүүлсэн ганц ч улс орон байдаггүй ба голдуу орлогын зарим нэр төрөлд хэсэгчлэн авч хэрэглэж буй туршлага бий.

1.1.2 Хосолмол орлогын татварын систем (dual income tax system)

Энэ системийнү ед цалин хөлс , хөрөнгө, тэтгэвэр , тэтгэмжийн орлогоос зохих хасалтуулгыг хассан цэвэр орлогын дүнд пропорционал хувь хэмжээгээр, **мөн нэмж** хөдөлмөр эрхлэлт, тэтгэвэр тэтгэмжийн нийт орлогод өсөн нэмэгдэх хувь хэмжээгээр татвар ногдуулдаг хавсармал аргыг хэрэглэдэг өбөөд ингэснээр хөдөлмөр эрхлэлтийн орлогод хөрөнгийн орлогоос өндөр татвар ногддог байна. Татварын хасалтын хэмжээ орлогын түвшнээс хамаарна. Энэ системийн хэрэглэж буй хөдөлмөр эрхлэлтийн орлогын өсөн нэмэгдэх хувь хэмжээ нь орлого дахин хуваарилах, төсвийн орлогыг бүрдүүлэх зорилгод илүүтэй чиглэгдсэн байдаг ч гэлээ орлогын нэр өрлийн хооронд өндөр татвартайгаас нь бага татвартай хэсэг рүү орлогоо шилжүүлж татвараас зайлсхийх, зугатах нөхцлийг бүрдүүлдэг.

Тухайлбал Норвеги, Финланд, Швед улсуудын татварын жишээн дээр харж болно.

Норвеги улс хувь хүний болон аж ахуй нэгжийн орлогын албан татварт 28%-ийн хэмжээтэй тогтмол татвар (flat tax) ногдуулдаг ч **үн** цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийн нийт орлого тодорхой босго давсан тохиолдолд өсөн нэмэгдэх (19,5% хүртэл) хувь хэмжээгээр нэмэгдэл татвар ногдуулдаг байна. Энэ нь хөдөлмөр эрхлэлтийн орлогод өсөн нэмэгдэх хувь хэмжээгээр, хөрөнгийн орлогод тогтмол хувь хэмжээгээр татвар ногдуулдаг 2 схем үйлчилж байна гэсэн үг . Норвегийн хосолмол орлогын татварын систем нь хоёр асуудлыг үүсгэсэн. Нэг дэх нь гадаадаас авах хөрөнгийн орлого болох ногдол ашиг, хүүгийн орлогод ногдох татвар нь Норвегид байгаа компаниас авах хөрөнгийн орлогод ногдох татвараас илүүтэйгээр татвар ногдож байсан. Хоёр дахь нь хөдөлмөр эрхлэлтийн орлого болон хөрөнгийн орлогод ногдуулж буй татварын дээд хэмжээний ихээхэн өрүү нь татвар төлөгчдийг хөдөлмөр эрхлэлтийн орлого олохоос зайлсхийж, хөрөнгийн орлогыг эрхэмлэх хандлага руу түлхэж байсан. Тиймээс Норвеги улс иргэдийн эзэмшиж буй гадаад, дотоодын компанийн хөрөнгийн орлогод адил татварыг ногдуулж, үүний хажуугаар хувийн орлогын дээд хязгаарыг бууруулж өгсөн.

1.1.3 Тогтмол татварын систем (flat tax system)


Сүүлийн хориод жил тогтмол татварын сэдэв татварын шинэчлэлийн өм асуудал болон хэлцэгдсээр байгаа бөгөөд тогтмол татварын систем нь хувь **үний**

бүх орлогод нэг хувь хэмжээгээр татвар ногдуулах арга юм. Тогтмол татвар нь хэдэн хэдэн төрөл зүйлтэй байдаг.

- Суурь татварын хасалдуулгагүйгээр хувийн бүх орлогод тогтмол нэг хувь хэмжээгээр татвар ногдуулдаг **пропорционал тогтмол татвар** (flat tax-proportional)
- Суурь татварын хасалдуулга хийсэн бүх орлогод тогтмол нэг хувь хэмжээгээр татвар ногдуулдаг **суурь чөлөөлөлттэй тогтмол татвар** (flat tax-basic allowance)
- Суурь татварын хасалдуулга хийсэн бүх орлогод тогтмол нэг хувь хэмжээгээр татвар ногдуулдаг боловч **хувь үний хуримтлал, хадгаламжийн орлогод татвар ногдуулдаггүй тогтмол татвар**
- Орлогын хэмжээнээс үл хамааран бүх хувь хүнд татварын хөнгөлөлт эдлүүлэх бөгөөд бүх орлогод тогтмол нэг хувь хэмжээгээр татвар ногдуулдаг **татварын хөнгөлөлттэй тогтмол татвар** (flat tax-basic income) хэмээн нэрлэдэг. Татварын хөнгөлөлтөөр дамжин чөлөөлж байгаа орлогын хэсгийг нийгмийн хамгааллын тэтгэвэр, тэтгэмжийг оролж байна гэж үздэг.

Хувь хүний орлогын татварт тогтмол татварын /пропорционал тогтмол татвар, суурь татварын хасалдуулгатай тогтмол татвар, татварын хөнгөлөлттэй тогтмол татвар/ хэлбэр бүрийг нэвтрүүлэхэд татварын дараахь цэвэр орлогод хэрхэн өөр өөр нөлөөлөлтэй болохыг дараахь графикаас харж болно.

Тогтмол татварын нэр төрлүүд



- BI-basic income (суурь орлого),
 BA- basic allowance (суурь хөнгөлөлт),
 Y –progressive rate (өсөн нэмэгдэх хувь хэмжээ)

Улс оронд нийгмийн ядуулаг хэсгийг татварын дарамтаас халах, татварын албаны татвар хураах зардлыг хэмнэх зорилгоор үх иргэддээ нийтлэг эдлүүлдэг татварын суурь хөнгөлөлт байдаг. Суурь хөнгөлөлт нь босго орлогыг татвараас өлө өлдөг бөгөөд орлогын эхний шатанд татварын хувийг тэглэх, тогтоогдсон хэмжээний орлогыг татвар ногдох орлогоос хасах, эсхүл ногдох татварыг нь хасах зэрэг аргуудаар хэрэгжүүлдэг. Тогтмол нэг татварын хувь хэмжээ хэрэглэх нь татвар хураах, цуглуулахад энгийн амард үр ашгийг

дээшлүүлдэг ч татвар төлөгчдөд татварын ачааллыг шударга хуваарилж чадахгүй байх шинж чанар илэрдэг.

Одоогоор Төв болон Зүүн Европын 9 улс оронд (хүснэгт 1) хувийн орлогод нэг хувь хэмжээтэй тогтмол татварын шинэчлэлийг хэрэгжүүлж, түүнийг аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хувь хэмжээний бууралттай хавсаргаж буй нь доройтолд ороод байсан эдийн засгийг сэргээхэд ихээхэн түлхэц болсон байна.

Хүснэгт 1. Хувь хүний орлогын тогтмол татвартай улсууд /2005 оны байдлаар/

№	Улс орнууд	Хувь хүний орлогын татварын хувь хэмжээ	Аж ахуйн нэгжийн орлогын хувь хэмжээ
1	Эстони	24 %	24%
2	Гүрж	12%	20%
3	Латви	25%	15%
4	Литва	33%	15%
5	Румын	16%	16%
6	Орос	13%	24%
7	Серб	14%	14%
8	Словак	19%	19%
9	Украйн	13%	25%
	Бүх улсын дундаж	18,8%	19,1%

Тогтмол татварын шинэтгэлийн чухал хэсэг бол хамгийн зохицсон, з татварын хувь хэмжээг тооцох, тогтоох, хэрэглэх явц бөгөөд дээрхи улсууд төсвийн орлогын хэрэгцээг хангах үүднээс хувь хүний бүх орлогод өндөр хувь хэмжээтэй нэг тогтмол татвар хэрэглэсэн боловч татварын орлуулах нөлөөлөл үүсч гажуудан, херенгэ, орлого улс хооронд өлөө тэй хөрвөх боломжтой тулгарч, хүн хүч, эдийн засгийн өөцийн байршилт татварын таатай орчинруу урвах бэрхшээлтэй учирч, нөгөө талдаа тогтмол татварын бага хувь хэмжээг баримтласнаар нийгмийн халамжийн системийг сулруулж, өсвийн орлогыг бүрдүүлэх, орлого дахин хуваарилах зорилгыг бууруулаад байгаа сургамжийг бас тооцох учиртай.

Жишээ нь: 2001 оноос ОХУ-т тогтмол татварын системийг маш амжилттай хэрэгжүүлсэн. Энэ татварын өөрчлөлт нь хувийн орлогын бааз суурийг өргөтгөж, өсөн нэмэгдэх хувь хэмжээг сольж, суурь татварын хасалдуулгаас дээшхи орлогод 13 хувьтай нэг л хувь хэмжээтэй татварыг бий болгосон. Энэ шинэчлэлээс өмнө хувь хүний орлогын татварын хувь хэмжээ 30 үртэл хувьтай байж, аж ахуйн нэгжийн орлогын татварын хувь хэмжээг 35% байсныг 24% болгон бууруулан өөрчилсөн. Шинэчлэлийн дараа эдийн засгийн өсөлт нэмэгдэж, 2000-2001 онд дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийн орлогын татварын жин 20%-иар өсч, орлогын нийт цэвэр өсөлт 25%-д хүрсэн. Тогтмол татварын шинэтгэл нь татварын системийг энгийн ойлгомжтой, ил тод болгож, татвараас зугатах явдлыг бууруулан, татварын хууль тогтоомжийг мөрдөхөд амар хялбар болгосон. Энэ шинэчлэлийн үндсэн амжилт нь татварын хувь хэмжээг өөрчилснөөсөө илүүтэй татварын албаны өөрийнх нь өөрчлөлт шинэчлэлд гол нөлөөлөх хүчин зүйл нь болсон байна.


2004 оноос Словак улсад тогтмол татварын системийг нэвтрүүлж, 25%-тай байсан хувийн болон 38%-тай байсан аж ахуйн нэгжийн орлогын татваруудыг өөрчлөн, ганц 19%-тай тогтмол татварыг бий болгосон. Шинэтгэлээр татварын ихэнх тусламж дэмжлэгийг үгүй болгон, харин суурь татварын хасалдуулгыг

ихэсгэсэн. Түүний хажуугаар Словакийн Засгийн Газар нийгмийн халамжийн тэтгэмжүүдийг багасгаж, шууд татварын ачааллыг шууд бус татвар руу шилжүүлсэн. Татварын систем нь энгийн хялбар, ил тод болж, бизнес ба хөдөлмөр эрхлэх, хөрөнгө оруулалт, хуримтлал хийх урамшил бий болж, хөрөнгийн нөөцийн байршлийн гажуудал багасч, татварын бааз өргөсч, үр ашиг өссөн. Өөрчлөлтийн дараа баруун Европоос их хэмжээний хөрөнгө оруулалтыг улс орондоо татаж чадсан бөгөөд эдийн засгийн өсөлтийг баттай хангадаг болсон зэрэг өөрчлөлтүүд гарсан байна.

ЭЗХАХБ-ын олон оронд нийтлэг орлогын татварын хэсэгчилсэн систем (semi-comprehensive personal income tax system)-ийг хэрэглэдэг ба энэ нь иргэдэд өөрт таатай татварын горим дүрэм, хувь хэмжээ, татварын босго, хөнгөлөлт чөлөөлөлт эдлэх сонголтын боломжийг олгодог. Дээрхи 3 системийг дагнан нэвтрүүлэхийг оролдсон ямар ч улс одоогоор байхгүй ба систем бүр нь тус тусын сөрөг бөгөөд эерэг талуудтай байсан. Тиймээс улс орон бүр энэ гурван системээс зохистой хэсүүдийг холимог байдлаар сонгон авч, өөрийн улсын онцлогт тохируулан нэвтрүүлсээр байна. Хэдий тийм ч хосолмол орлогын татварын систем (орлогын нэр өрөлд тусгайлсан хувь хэмжээ ашиглах) болон тогтмол татварын системийг илүүтэй сонирхох, сонгох чиг хандлага олон оронд ажиглагдаж, ялангуяа тогтмол татварын системийг хэрэгжүүлэх үйл явц өргөн дэлгэр болоод байна.

2.Монгол Улсын Хувь хүний орлогын албан татварын өнөөгийн төлөв байдал

1991 оноос Хувь хүний орлогын албан татварын хуулийг анхлан боловсруулж мөрдсөнөөс хойш 1993 оноос эхлэн өнөөг хүртэл хэд хэдэн удаа өөрчилж ирсэн ба бодлогын чанартай хийгдсэн хамгийн томоохон шинэчлэл нь 2006 оны хуулийн өөрчлөлт байлаа. Энэ өөрчлөлтөөр татварын бааз суурийг өргөтгөж, татварын хувь хэмжээг хялбаршуулан, 0- 30 хүртэл өсөн нэмэгдэх хувь хэмжээг хэрэглэж байсныг хувийн орлогын ихэнх нэрэрөлд тогтмол 10%-иар татвар ногдуулахаар хуульчилж хувийг бууруулсан үйл явц юм. Энэ шинэтгэлийн гол цөм болох татварын жигд 10 хувийн бага хувь хэмжээ нь татварын системд шударга, үр ашигтай, энгийн байх зарчмыг үйцэлдүүлж, татварын ачааллыг жигдүүлснээр хувь хүмүүсийн орлого, хөрөнгөө нуух явдлыг бууруулж, татвараа тайлагнах, төлөх явц сайжирч, төсвийн орлого нэмэгдэнэ хэмээн тооцоолсон. Дээрх хуулийн өөрчлөлт 2007 оны 01 сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон бөгөөд хуулийн үйлчлэл татварын хуулийн хэрэгжилтэд хэрхэн нөлөөлснийг хувь хүний татварын орлого дотоодын нийтүбээгдэхүүн болон татварын нийт орлогод эзлэх жин, татварын өрийн хувь, татварын орлогын дүн гэсэн голлох үзүүлэлтээс харж дүгнэж болох юм.




	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он
ДНБ-д эзлэх хувь	2.60	2.40	1.80	1.94	2.16
Татварын орлогод эзлэх хувь	8.40	11.80	7.20	10.20	14.20

Татварын албаны мэдээгээр хувийн орлогын татвар дотоодын нийт орлогын хувь болж эзлэх хувь 2005-2006 онд 2.6%-2.4% байснаа 2007-2008 онд 1.8%-1.9% болж бууран 2009 онд 2,16 хувийг эзэлж байгаа нь (график 3) энэ төрлийн татварын ачаалал буурсаныг, харин нийт татварын орлогын дүнд 2005 онд 8.4%, 2006 онд 11.8%, 2007 онд 7.2%, 2008 онд 10,2%, 2009 онд 14,2%-ийг (график 3) тус тус эзэлж байгаа нь энэ татварын өсвийн ач холбогдол нөлөө бүхий биш байгааг илтгэн харуулж байна.

2005-2009 оны татварын нийт өрд ХХОАТ-ын өрийн эзлэх хувийн жингийн судалгаа /тэр бум төгрөгөөр/

	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он
Татварын нийт өр	66.5	89.5	84.7	274.6	75.5
ХХОАТ-ын өр	10.6	11.2	8.0	15.1	2.3
Эзлэх хувь	16	12.5	9.4	5.5	3.0



Харин хувь хүний орлогын татварын өр 2005-2008 онуудад 16 %-иас 8.8% болтлоо буурсан, нөгөө талдаа татварын орлогын хэмжээ 2005 онтой харьцуулахад 52.1 тэрбум төгрөг буюу 78%-иар, 2006 оноос 29.2 тэрбум төгрөг буюу 32%-иар өссөн нь татварын бааз суурь өргөсч татварын орлого нэмэгдсэн, татвар төлөлт сайжирсан байдал ажиглагдаж байна. Үүнд мэдээж татварын хуулинд орсон өөрчлөлтүүд, эдийн засгийн өсөлт, инфляци зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн нь ойлгомжтой билээ.

Манай улсын энэхүү еерчлелтийг орчин цагийн шинэчлэлийн чиг хандлага, олон улсын туршлагатай жишин харьцуулахад:

Хувийн орлогын дийлэнх нэр терелд нэгдсэн нэг хувь хэмжээ, багаахан орлогын терелд тусгайлсан хувь хэмжээг хэрэглэж байгаа нь тогтмол татвар (flat tax) ба хосолмол орлогын (dual income tax) татварын шинж чанарыг агуулсан холимог (semi dual-semi flat) системийн арга нэвтрүүлж байна гэж үзэхэд болохоор байна. Хуулинд зааснаар хувь хүний албан татвар ногдох нийт есен нэр терлийн орлогын зургаад нь 10%-ийн тогтмол нэг хувь хэмжээгээр татвар ногдуулан, хеделмер эрхлэлтийн орлогын хэмжээнээсүл хамааран бүх хувь хүнд татварын хөнгөлөлт эдлүүлж байгаа нь татварын хөнгөлөлттэй тогтмол татварын (flat tax-basic income) хэлбэр байна. Тогтмол татварын энэ өөрчлөлт нь татварын хувь хэмжээний олон шатлалыг үгүйсгэн нэг хувь хэмжээтэй болгох, татварын суурь хөнгөлөлтийг хадгалсан татварын олон терлийн хөнгөлөлт чөлөөлөлтийг багасгах, хуулийн нарийн түвэгтэй байдлыг өөрчлөн, татварын бага хувь хэмжээг хэрэглэх гэсэн гурван үндсэн хэсэг дээр төвлөрч байна.

Манайд улсад хэрэгжүүлж байгаа тогтмол татварын шинэчлэл нэсв ийн орлогыг бүрдүүлэх, орлого хуваарилах зорилго, татварын шударга, үр ашигтай, энгийн байх зарчим хэрхэн хангаж, хэрэгжиж буйг дүгнэхэд:


Татварын хэвтээ чиглэлд шударга байдлыг нэлэхдээ бүх хүний бүх терлийн орлогыг татварт хамруулж байгаа эсэх, татварын хууль хүн бүрт адил тэгш үйлчилж байгаа эсэхийг тодорхойлох явдал бол татварын босоо чиглэлд шударга байна гэдэг нь их бага хэмжээний харилцан адийг орлоготой хүмүүст хэрхэн шударгаар татвар ногдуулах вэ гэсэн асуудал юм.

2.1 Монгол улсын Хувь хүний орлогын албан татвар шударга байхын тухайд:

Манай улсад хэдийгээр орлогын түвшнээс үл хамааран бүх хүний орлогод ганцхан жигд 10 хувийн татвар ногдуулж, хуулийн таатай орчиүүсгэн, хувь хэмжээний хувьд шударга байгаа ч зарим орлогын терелд татвар ногдуулахгүй байх, татварын хэсэгчилсэн чөлөөлөлт эдлүүлэх, заримынх татварыг чөлөөлөх, заримаас нь татвар бүрэн болон бүр хураан авч чадахгүй байна.

2.1.1. Хэдийгээр хуулинд хеделмер эрхлэлтийн орлогоүйл ажиллагааны орлого, херенгө ба херенге борлуулсны болон бусад бүх орлогыг татварын суурьт хамруулан татвар төлөхөөр заасан боловч 2005-2009 оны байдлаар ХХОАТ-ын нийт орлогын 76%-87%-ийг цалин, өдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах өдөлмөр эрхлэлтийн орлогоос суутган авсан татвар бүрдүүлж, үйл ажиллагааны орлогын (ХХОАТТайлан, тогтмол патент, жишиг татварын нийт дүн) татварын эзлэх жин 2005-2009 онуудын жилийн дунджаар дөнгөж 4.2% байгаа нь хувиараа бизнес, хөдөлмөр эрхэлсэн, түрээс, хувьцаа борлуулсан, эрх ашиглуулсны орлогын иргэд татварт бүрэн хамрагдахгүй, татварын дийлэнх ачаалал тогтмол ажлын байртай, гэрээгээр хеделмер эрхэлж буйүүсгийн нуруун дээр бууж байгаа шударга бус дүр зураг харагдаж байна.

(График 5)




ХХОАТ-ын нийт дүнд эзлэх хувийн жингийн судалгаа

	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он
суутган-1 татварын эзлэх хувь	76	79	81	87	85.7
үйл ажиллагааны орлогын эзлэх хувь	4.2	4.7	7.1	2.5	2.27

Мөн 2005-2009 оны байдлаар Хувь хүний орлогын албан татвар тодорхойлох хуудсаар тооцоо хийсэн татвар төлөгч иргэдийн тоо болон төлсөн татварын хэмжээг (график 6) ажиглахад татварын хуулийн таатай орчинг үүсгэсэн ч дээрх үзүүлэлтүүд буурсан байгаа нь татвараа еерее тодорхойлон төлөх ёстой хувиараа бизнес, жөдөлмөр эрхлэгчдийн орлого нуугдмал хэлбэрт байгааг илтгэн харуулж байна.

2005-2009 онд ХХОАТТХ-аар татвараа тайлагнаж, төлсөн иргэдийн тоо ба төлсөн татварын судалгаа /сая төгрөгөөр/

	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он
Татвараа тайлагнасан иргэний тоо	48758	44420	39881	40404	40367
Төлсөн татварын дүн	850.2	1628.3	3116.0	2946.0	19060.3



2.1.2. Үйл ажиллагааны орлоготой зарим иргэдээс орлогыг тодорхойлох боломжгүй шалтгаанаар үйл ажиллагааны нарийн судалгаа, орлого зардлын тооцоог үл харгалзан 10 хувийн татвараас еер хэлбэрээр жишиг, тогтмол тоон татвар ногдуулан авч байна. Жишээ нь ажилүйлчил гээний хөлс, үнэ өртөг өндөртэй алт мөнгөний дархан, автомашины засвар үйлчилгээ, барилгын засал, засвар чимэглэл, үсчин гоо сайхан гэх мэт бүртгэл хөтөлж болохуйц, эрэлт хэрэгцээ ихтэй, орлого ашиг сайтай ажил үйлчилгээний төрлөөс патент нэрийн дор байнгын бага тогтмол татвар ногдуулах нь үй бус байна. Малчдын малын толгойн татваргүй болж, малчдын орлогыг татварт хамруулах асуудал дэмж хү ндрэлтэй болж, тэднийг татварт хамруулах бараг боломжгүй болж байна.

2.1.3. Херенгийн орлогын чухал хэсэг болох хувьцааны ногдол ашиг, хүүгийн орлогыг 2013 он ү ртэл татвараас чөлөөлж байгаа нь хуримтлал, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх эдийн засгийн бодлогын татварын урамшуулал хэмээн тайлбарлаж байгаа ч өнөөгийн манай нөхцөлд нийгмийн херенгелег хэсгийг дэмжсэн, тэдэнд илүү ашигтай байхаар тусгагдсан хуулийн заалт болж, татварын шударга байх зарчмыг ихээхэн ганхуулж байна. Сүүлийн үед нийгмийн гишүүдийн дунд баян хоосны ялгарал ү чтэй явагдаж, цөөн тооны чинээлэг гэр ү лд херенге, орлогын хуримтлал ногдож буйг төрийн өндөрлөгт байгаа албан хаагчдын херенге орлогын мэдүүлгээс билээхэн харж болно. Тэдний херенге, орлогын мэдүүлгээс харахад орлого өндөртэй гишүүдийн дийлэнх нь үл хөдлөх херенге, хадгаламж, үнэт цаасаарх херенге оруулалт ихтэй, ү рээс, хувьцаа худалдан борлуулсан, ногдол ашиг, хүүгийн орлоготой байх магадлал ихээхэн ажиглагдаж байна.

2.1.4. Хувь хүний татвар ногдох орлогын суурьт бусдаас /хуулийн этгээд болон хувь хүнээс/ үнэ төлбөргүй авсан бараа, ажил, ү йлчилгээ, биет ба биет бус херенгийн орлогыг хамруулахгүй байна. Үүний тод жишээ нь иргэд хооронд байр сууцаа шилжүүлэхдээ татвараас зайлсхийхийн тулд бэлэглэлийн гэрээ үйлдэх явдал түгээмэл тохиолддог билээ.

2.1.5. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн томоохон хэсэг болсон үү хдийн сургалтын төлбөрийн хасалтад өлөөлөх дүнгийн хязгаар тогтооүйгээс олон хүүхдээ гадаадад сургаж буй өндөр орлоготой иргэн их, бага орлоготой нэг хүүхдээ дотоодод сургаж буй иргэн бага хөнгөлөлт эдлэхээр шударга биш нөхцөл байдал үүсч байна. Манай улсад татвар төлөх нэгж өрхөөр биш хувь хүн байдаг нь гэр бүлийн төсвөөс гардаг хүүхдийн сургалтын төлбөр, орон сууцны зардлын хасалтыг өрхийн гишүүд бүрд давхардуулан өдлүүлэх боломж байгааг хаах нь зүйтэй.

2.1.6. Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал, тэдгээртэй адилтгах шагнал өргөн дэлгэр, түгээмэл болж, шагналын дүн ихээр өсч, урлаг соёл, спортын тамирчид, хүмүүс нийгмийн өндөр орлоготой давхаргад шилжих үзэгдэл ажиглагдаж байгаа тул тэдэнд ногдуулах татварын хувь хэмжээг 5 биш, бусадтай адилтган 10 хувь болгох нь шударга зарчимд нийцэх болов уу хэмээн үзэж байна.

2.1.7. Нийгмийн орлого багатай ядуулаг иргэдийг татварын дарамтаас чөлөөлөх тэдний амьдралын доод түвшинг хангах зорилгоор хэрэглэгддэг татварын суурь хөнгөлөлт болох 84000 төгрөгийн татварын хасалтыг хувь хүний орлогын бүх төрөлд, ногдсон нийт татварт нь хэрэглэхгүй байна. Одоогийн хуулиар нийгмийн бодлогын болон татварын хөнгөлөлтийн чухал хэсэг болох татварын энэ хасалтыг

зөвхөн цалин хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлоготой иргэдэд эдэлж, хувийн бизнес, бусад төрлийн орлоготой иргэд хүртэхгүй байгаа нь шударга бус учир бүх хүнд хамаатай нийтлэг хөнгөлөлт болгох нь зүйтэй болов уу.

2.1.8. Үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээний асуудал цэгцтэй, боловсронгуй болоогүйн улмаас иргэдийн бизнесийн зориулалтаар ашиглаж буй үл хөдлөх хөрөнгийн болон үл хөдлөх хөрөнгө борлуулсны татварыг, АТӨЯХ эрэгслэлийн бүртгэлийн процесс татварын алба, төрийн зохих байгууллагуудын хооронд өв зохистой уялдаагүйгээс болж түүнд ногдох албан татварыг тус тус бүрэн гүйцэд хурааж чадахгүй байна.

Дээрхи байдлаар шударга бус байдлыгүү сгэн , татварын ачааллыг хүмүүст тэнцвэргүй үүрүүлж, шударга бус хуваариласнаас татварын хуулийн хэрэгжилт алдагдаж, төсвийн орлого өрдэхгүй, хүмүүс хооронд хөрөнгө баялгийн тэгш бус ялгаа үүсч нийгэмд тогтворгүй байдал үүсэх үр дагавартай. Татварын шударга байх зарчим нь үү ний орлого хуваарилах зорилготой нягт холбогддог. Хөгжилтэй орнуудад дийлэнх иргэд нь жигд дундаж амьдралтай байгаа нь татвараар орлого хуваарилах бодлогыг амжилттай хэрэгжүүлсний үр дүн хэмээн үзэж болно.

2.2 Монгол улсын Хувь хүний орлогын албан татвар үр ашигтай байхын тухайд:

Манай улсад хувь хүний орлогод есөн нэмэгдэх биш 10 хувийн адил хэмжээтэй татвар хэрэглэж байгаа нь :

2.2.1 есөн нэмэгдэх хувь хэмжээний нөлөөлөл устаж (ендер хэмжээний татвар нь хүний хөдөлмөрлөх сонирхлыг бууруулж чөлөөтэй байхыг эрхэмлэх зан авирт нөлөөлдөг) татварын орлуулах нөлөөлөл үгүй болж, хөдөлмөрлөх сонирхлыг төрүүлсэн

2.2.2 орлогын бүх төрөлд (цалин хөлс, үйл ажиллагаа, хөрөнгийн орлого гэх мэт) 10 хувийн адил хэмжээний татвар үйлчилж байгаа нь өндөр татвартай орлогоос бага татвартай орлогын төрлийн хооронд орлогоо шилжүүлж татвараас зугатах явдал барагүй болж, үр ашгийн алдагдал гарах нөхцлийг хаасан үр ашигтай байх зарчимд нийцсэн тогтмол татварын систем үйлчилж байна хэмээн үзэж болохоор байна.

Гэвч татварын хуулинд байгаа байр, орон сууцны зардал, хувьцааны ногдол ашиг, хүүгийн орлогыг татвараас чөлөөлж байгаа заалт нь хүмүүс татвар багатай үйл ажиллагаа, орлогын төрөлд нөөцөсө байршуулж түүнээс ч үр ашигтай байх бусад боломжийг алдаж байгаагүйгсгэх аргагүй. Жишээ нь: орон сууц худалдан авах, барих зардлыг татварын орлогоос хасаж байгаа нь иргэнүүх ний бизнес эрхлэх, орлого ашиг олох сонирхлыг бууруулж, татварын чөлөөлөлт эдлэх зорилгоор бизнесийн эргэлтэд хамааралгүй орон сууц, байр худалдан авах мөн хувьцааны ногдол ашиг, хүүгийн орлого татварт хамрагдахгүй байгаа нь хүмүүсийг бизнесийн хөрөнгө оруулалт хийж, аж ахуйнү йл ажиллагаа эрхлэх сонирхлыг бууруулж, сул чөлөөтэй хуримтлалаа хадгаламж, мөнгө зээлдүүлэх идэвхгүй хэлбэрүү түлхэж, нөөцийн шийдлийг гажуудуулах нөлөөлөлд автуулж байж болох юм.

Хувь хүний үйл ажиллагааны орлогоос татвар хурааж чадахгүй байгаа нь татвараас нуугдах боломж олгон, иргэдийг хуулийн этгээд байгуулахгүйгээр ганцаарчилсан бизнес эрхэлж, оюуны нэгдэл болон хөдөлмөр хуваарилалтын хамтын хүчний илүүтэй үр өгөөжийг орхигдуулж, орлого олох боломжоо төлсөн татварын дүнгээс илүү хэмжээгээр алдахад хүргэдэг. Хэдийгээр ийм тооцоолол олон улсын амьдралд их гардаг ч манай улсын хувьд энэ тал дээр хийсэн нарийн судалгаа байхгүйн учраас үр ашгийн тодорхой нөлөөллийг тодруулан хэлэхэд бэрхшээлтэй байна.

Цаашид манай улс байгалийн баялагаа ашиглан эдийн засгийн эргэлтэд оруулан, гадна дотны хөрөнгө оруулалт хийгдэхийн хэрээр ажлын байр нэмэгдэж, ард иргэдийн хөдөлмөр, бизнес эрхлэлт сайжирч, хувь хэний орлогын татвар есөн нэмэгдэх нь нэн ойлгомжтой. Иймд хувь хэний орлогын татварыг үрэн дүү рэн хураан авах нь татварын шударга үр ашигтай байх нөхцлийг хангасан төсвийн орлогыг бүрдүүлэх зорилгыг хэрэгжүүлсэн нэн чухал процесс юм.

2.3 Монгол улсын Хувь хүний орлогын албан татвар энгийн байхын тухайд:

Хувийн орлогын татвар нь тухайн улс орны Ү хий л иргэдэд хамааралтай, давхарга бүрийн эрх ашигт аль болох шударга, үр ашигтай байдлаар үйлчлэхээр чиглэгдсэн байдаг нь хуулийн хэрэгжилтийг хангах, хянаж мөрдөхөд хамгийн төвөгтэй, хамгийн хүнд нь байдаг. Татварын хууль тогтоомж тэр тусмаа иргэн татвар төлөгчдөд зориулсан хувь хүний орлогын албан татварын хууль нь энгийн ойлгомжтой, зүйл заалтын уялдаа холбоо сайтар зохилдсон, хэрэглэхэд хялбар байх нь хууль хэрэгжих таатай нөхцлийг бүрдүүлж, татвар шударга, үр ашигтай байх бололцоог бүрдүүлж өгдөг.

Татварын хувь хэмжээ татвар төлөгчдийн зан төлөв, авир аягийг жоло одож байдгаараа татвар энгийн байх зарчимд чухал нөлөөтэй байдаг. Манай улс хувь хүний орлогын татварт ганц өрлийн тогтмол хэмжээт 10 хувийн татвар нэвтрүүлснээр татвар төлөгчдөд хууль дагаж мөрдөх өртөг бага, татвараа тооцож ногдуулах, тайлагнах, өлөх процесс амар, татварын албанд хуулийг хянаж хэрэгжүүлэх явц хялбар байгаа нь энгийн байх зарчимд илүүтэй нийцэж байна гэж дүгнэхэд болно. Хувийн орлогын энэхүү татварын ялгаваргүй үйлчлэл нь татвараас нуугдах, зугатах, бултах цоорхойг багасгаж, татварын гажуудлын өлөөллийг саармагжуулан, хөдөлмөрлөх, хуримтлуулах, хөрөнгө оруулах бүтээлч ажиллагааг бий болгож эдийн засгийн өсөлтийг хангахад өөрийн гэсэн эерэг нөлөө үзүүлж буй нь ч дамжиггүй.

Гэвч манай улсын мөрдөж буй хууль тогтоомж нь энгийн байх зарчмаас хазайсан жирийн татвар төлөгчдөд ойлгомжгүй үг хэллэгтэй, хууль хооронд болон хуулийн заалт хоорондын зохицол, хамаарал эрчигдсэн, хийдэл цоорхойтой, олон тооны маягт, загвартай, сунжирч үргэлжилсэн аргачлал заавартай, татвар төлөлтийн давтамж ихтэй, олон өрлийн татварын данстай, ойлгоход өвөгтэй татварын тайлантай зэрэг татварын алба болон татвар төлөгчдийн аль алинд нь хууль хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулсан төвөгтэй байдал нилээдгүй байна.

Татварын энэхүү нарийн түвэгтэй байдал бүхэлдээ нийгэмд дараахь төрлийн зардал, чирэгдлийг бий болгож байна.

- 2.2.1 Иргэд татвараа төлөхийн тулд орлого зардлаа бүртгэх, татварын хууль дүрэм судалж мэдэх, татварын өвлөлгөө авах, хүн хөлслөх, тайлан маягтаа олж авах, цаг хугацаа зарцуулах зэрэг үйл ажиллагааны зардал үүсдэг. Татвар улам өвөгтэй нарийн болохын хэрээр татварын өвлөлгөө өгөх бизнес өргөжин тэлж, татварын үйлчилгээний хөлс ихээр гарах болж байна. Нөгөө талдаа татварын үйлчилгээг иргэдэд хүргэдэг татварын албаны бүтэц томорч, төсвөөс ихээхэн хөрөнгө мөнгө шаарддаг болоод байна.
- 2.2.2 Үйл ажиллагаа эрхлэгч иргэдийн хувьд татвар төлөх, тайлагнах явц нь аж ахуй нэгж, компанитай адил нарийн түвэгтэй байгаа нь жижиг бизнес эхлэх, эрхлэхэд эргэлзээ төрүүлж, эдийн засгийн үр ашигтай шийдэлд саад учруулж байна.
- 2.2.3 Татвар төлөгч орон сууц, хүүхдийн сургалтын зардлаар татварын хөнгөлөлт чөлөөлөлт эдэлж, буцаан олголгоо авахын тулд олон өрлийн нотолгоо шаардагдаж, үүнийг мөрдөхтэй холбоотой и хээхэн хэмжээний баримт тооцоо, бичиг цаас бүрдүүлж, цаг хугацааны гарздал үүсч, мөн татварын

албанаас хувийн амьдралын мэдээлэл **үү** хэтэрхий оролцох хандлага гарч байна.

2.2.4 Татварын тодорхойгүй, хоёрдмол утгатай томъёолсон, эсвэл өөр хоорондоо зөрчилдсөн, ойлгомжгүй утга санаа нь татварын алба болон татвар төлөгчийг татварын тооцоо, дүнг алдаа мадагтай гаргах санамсаргүй зөрчил руу түлхэж байна.

2.2.5 Татварын хуулийн тогтворгүй байдал нь татварын алба, татвар төлөгчдөд татварын хуулийг ойлгож хэрэгжүүлэх, мөрдөх, хүн хүчээ сургахаас авахуулаад татварын тайлан маягт, заавар журмыг өөрчлөх, татварын тооцооны программ хангамжийг шинэчлэх өртгийг үүсгэж байна.

2009 оны байдлаар Дэлхийн банкнаас 183 орны татварын системийг бизнес эрхлэхэд таатай байдлаар нүнэлж дүгнэхэд Монгол улсын татварын орчин 69 дүгээр байрт эрэмблэгдэж байгааг цэгнэн харахад илүүдэх юун. Татварын бодлогын шалгуур болсон шударга, үр ашигтай, энгийн байх зарчмууд, орлого үрдүүлэх, дахин хуваарилах зорилтууд харилцан уялдахын гадна өөр хоорондоо зөрчилдөж байдаг зүй тогтолтой тул манай улс өнөөгийн нөхцөл байдалд тавигдаж байгаа хөгжлийн зорилттойгоо уялдуулах алийг нь илүүтэйд тавьж, алийг нь сулруулах зохистой харьцааг тооцон татварын бодлогоо боловсруулах хэрэгцээ шаардлага байна.

3. Хувь хүний орлогын албан татварын талаархи шийдвэрлэх асуудлууд, хэрэгжүүлэх арга хэмжээ

Хувь хүний орлогын татварын орчин цагийн зонхилох чиг хандлага, татварын зорилго, зарчим хэрхэн хангагдаж, хэрэгжиж буйд үнэлэлт, дүгнэлт хийж цаашид татварын хууль тогтоомж болон хуулийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр дараахь саналуудыг дэвшүүлж байна.

3.1 Татварын хууль тогтоомжийн талаар

3.1.1 ХХОАТ-ын хуулийн татвар тайлагнах хэсэгт хувь хүн бүр жилийн орлогын албан татварын тайлан гаргах, шалгуур үзүүлэлтийг “тухайн татварын жилд хувь хүний нийт орлогын хэмжээ 2.4 сая төгрөгөөс дээш давсан бол” гэсэн босго байхаар тогтоож өгөх. Энэ нь нэг талаар татвар хураах зардал ихтэй боловч, нөгөө талаар татвар төлөгчдийг бүрэн татварт хамруулах, хяналт сайжрах сайн талтай. Цаашид энэ нь татвар төлөгч иргэн бүрийг орлого, татвараа тайлагнадаг системд шилжүүлэх шилжилтийн үе шат болох ба мэдээллийн маш сайн систем шаардлагатай болно.

3.1.2 Татварын суурь хөнгөлөлт 84000 төгрөгийн татварын хасалтыг нийгмийн орлого багатай, ядуулаг иргэдийг татварын дарамтаас өлөөлөх тэдний амьдралын доод үвшинг хангах зорилгоор хувь хүний орлогын бүх төрөлд, ногдсон нийт татвараас нь хөнгөлдөг болох. Тэгэхдээ энд татварын хөнгөлөлтийн дүнг ажилгүйдлийн тэтгэвэр тэтгэмж, хөдөлмөр хөлсний доод хэмжээтэй уялдуулж тооцохгүй бол сөрөг нөлөөлөл үүсэх магадлалтай. Хэрэв татвар төлөгчид дараахь цэвэр орлого нь нийгмийн халамжаас олгодог тэтгэвэр тэтгэмжээс бага байвал ядуурлыг бууруулах биш нэмэгдүүлэх, нийгмийн халамжид дулдуйдаж амьдардаг, ажил эрхэлдэггүй, баялаг бүтээдэггүй нийгмийн бүхэл бүтэн анги давхаргыг бий болгоход хүргэнэ.

3.1.2 Ногдол ашиг, хүүгийн орлогоос албан татвар ногдуулан авах

- 3.1.3 ХХОАТХуулийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн заалт болох хүүхдийн сургалтын зардалын тухай 24 дүгээр зүйлийн 24.6 заалт, 26 дугаар зүйлийн 26.1.5 заалтуудын зөрчлийг арилгаж, албан татвараас чөлөөлөгдөх орлого уу, албан татвараас хасагдах хөнгөлөлт үү гэдгийг нэг мөр болгох
- 3.1.4 Хүүхдийн сургалтын зардлыг татварын орлогоос чөлөөлөхдөө байр орон сууцны адил хасалтын хэмжээнд хязгаар тогтоожгох. Учир нь энэ чөлөөлөлтийг гүйцэтгэлээр нь хасч байгаа нь орлого ихтэй чинээлэгэрхэд илүүтэй ашигтай байж, орлого багатай ядуу өрхөд бага нөлөөлөлтэй байна.
- 3.1.5 Засгийн газрын Иргэний бүртгэлийг төгөлдөржүүлэх үйл явцтай уялдуулан иргэдийг регистрийн дугаар, ургийн овог, өөрийн овог нэрийг агуулсан тэмдэгтэй болгох, түүний ашиглах, хэрэглэх асуудлыг татварын болон бусад хууль тогтоомжид тусгажгох. Энэ нь татвар өлөгч иргэн хүний бүртгэл тооцоо бүрдэл болох, чанаржих, хүчин төгөлдөр болох, хариуцлага сайжрах зэрэг чухал ач холбогдолтой байна.
- 3.1.6 ТЭХуулинд бусад байгууллагынүүрэг хариуцлагын хэсэгт татварын хяналтад шаардлагатай мэдээ, мэдээлэл солилцох, хамтран ажиллах байгууллагуудыг хамруулж, тэднийг үүрэгжүүлэх, хариуцлага тооцох зүйл заалт оруулах. Энэ нь татвараа өөрөө тодорхойлохгүй байгаа татвар төлөгчдийг татварт хамруулах хөндлөнгийн мэдээллийг бүрдүүлэх, тэдэнд тавих хяналтын хүрээг бий болгоход ихээхэн нөлөөлөлтэй ажил болно.
- 3.1.7 Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал, тэдгээртэй адилтгах шагналын орлогод ногдох татварын хувь хэмжээг 10 хувь болгох
- 3.1.8 Үйл ажиллагааны орлогын татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо хувь хүний бизнесийн хөрөнгө оруулалтад бус хэрэглээнд зориулсан зээлийн хүүг хасахгүй байх заалт оруулах
- 3.1.9 ҮХЭХ-ийн үнэлгээний боловсронгуй бус байдлаас улбаалан хөрөнгийн татвар ихээхэн дутуу ногдож буй хуулийн цоорхойг залруулж, ҮХЭХАТ-ын хуулинд хөрөнгийн зах зээлийн бодит үнэлгээг хэн хийх, яаж хийх, юуг үндэслэх заалт нэмж боловсруулан оруулах
- 3.1.10 Жишиг болон тогтмол татварыг боловсронгуй бодлоос ажил үйлчилгээний хамрагдах өрөл, татварын хэмжээг оновчтой тогтоох зорилгоор байршил, хэмжээ, үйл ажиллагааны төрлөөр орлого зардлын нарийн хэмжилт, судалгаа хийх ажлын хэсэг байгуулах, “Жижиг татвар төлөгчийн албан татварын тухай хууль”-ийн төслийг сайжруулах санал өгөх
- 3.1.11 Авилгалын эсрэг хуульд төрийн албан хаагчид хөрөнгө, орлогын мэдүүлгээс гадна хувь хүний орлогын албан татварын тайланг хамт гарган ирүүлэх зүйл заалт нэмж оруулж өгөх, ингэснээр орлого, өрөнгө чинээ ихтэй төрийн албан хаагчдыг татварт хамруулж, нийтээрээ хуулийнмнө адил тэгш, шударга байж, төрд итгэх олон түмний итгэл сэргэн, татвар шударга байх зарчим хэрэгжинэ.
- 3.1.12 Хувь хүний орлогын татварын ногдох орлогын төрөлд бусдаас /хуулийн этгээд, иргэдээс/ үнэ төлбөргүй авсан бараа, ажил, үйлчилгээ, биет ба биет бус хөрөнгийн орлогуудыг хамруулж өгөх. Энэ суурийг орлогын баазад оруулж өгөөгүйгээс татвараас зайлсхийх хуулийн цоорхой үүсч, хувь хүний орлогын бүх нэр төрлийг татварт хамруулаагүй шударга бус байдал үүсч байна.

3.2 Татварын албаны үйл ажиллагааны талаар

3.2.1 Татвар өлөгчийг хууль биелүүлж буй төлөв байдлаар нь ангилан тэдний хандлагад тохирсон татвар үйлчилгээний стратеги зохиох. Татвараа өөрөө тодорхойлох тогтолцооны тулгуур багана болох татварын үйлчилгээ ба хууль сахиулах хоёруйл ажиллагааны зөв зохистой харьцаа нь

татварын хууль тогтоомжийг сайн дураар сахин биеллэх нөхцлийг бий болгодог. Иймээс үнэнч шударгаар татварын хуулийг сахин биелүүлж буй татвар төлөгчид үүргээ биелүүлэхэд нь тусалж дэмжих, харин шударга бус татвар төлөгчийг олж тогтоон, тэдгээрт хуулийн албадлагын арга хэмжээ авах шаардлага байна. Иргэд, татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлэх хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх. Үүнд: жишээ нь дараахь түгээмэл ажлуудыг багтааж болно.

- Ардчилсан, шударга, эрүүл саруул ни йгэм бол татвараа өлсөн, мөн бусдаас илүүтэй татварын хувь нэмэр оруулсан иргэдээ хүндэлдэг, түгээрээ бахархдаг. Тэдгээр иргэд өөрийн авьяас билэг, эрдэм ухаан, ажил хөдөлмөрөөрөө орлого, хөрөнгө, баялаг бүтээж эргээд үндэстнээ тэжээн тэтгэж их хэмжээний татварыг улс нийгэмдээ төлж, төлсөн татвар нь өөрийн дахин хуваарилалтаар өөр бусад иргэдэд хүртэж байдаг. Харин татвар төлөгчгүй байгаа иргэдийн хувьд нийгмийн х уримтлалд татвараа төлөөгүй төрд нэмэр дэм болоогүй байж нийгмээс үйлчилгээ авах, нийгмийн харилцаа, зохицуулалтад оролцох гэдэг нь шударга бус, иргэн хүний хувьд үнэхээр ёс зүйгүй явдал хэмээн үзэж, энэ нийгмийн үзэл санааг олон нийтэд төлөвшүүлсэн байнгын сурталчилгаа зохион байгуулах
- Татварын хуульчдийг боловсронгуй болгох үүднээс т огтмол хуваарийн дагуу (жишээ нь: татвар төлөгчдийн өдөр) татвар төлөгчидтэй харьцаж нээлттэй хэлэлцүүлэг хийн, олон үмнийг сонсох (public hearing), санал асуулга (feedback) зохион байгуулах
- Татварын ил тод байдлыг хангах зорилгоор татварын орлогын зарцуулалт бүрийг тайлагнаж байдаг ном хэвлэмэл хуудас тараах, цахим хуудас ажиллуулдаг АНУ туршлагыг нэвтрүүлэх
- Татвар төлөгчийн татварын албанд хандсан хандлага бүрт (утас, захиа, биеэр ирж уулзах, интернет, уулзалт) талархаж ханддаг харилцааны соёл, үйлчилгээний стандарт тогтоож, дахин татварчдийг эргүүлэн татахуйц таатай нөхцөл бололцоогоор хангаж байх гэх мэт

3.2.2 Татвар өлөгчийн бүртгэлийн баазыг эрс сайжруулах. Татвар төлөгчийн бүртгэлийг нийгмийн хүн амын бүртгэлийн уг сурвалж болох улсын бүртгэлийн газрын хүн амын суурь бүртгэл, сонгуулийн бүртгэл, нийгмийн даатгалын байгууллагын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, тэтгэвэр тэтгэмж авдаг иргэдийн бүртгэл, өөрөөс иргэд эд олгох байгалийн баялгийн хишиг, хувь хүртээмжийг дагасан төр, захиргааны байгууллагын тооллогын бүртгэлийн баазтай нягт холбож өгөх нь иргэдийг татварт бүрэн хамруулах, татвараас зайлсхийх нөхцлийг хаах чухал хөшүүрэг болно.

3.2.3 Татварын суутган тооцооллолт, тайлан ирүүлэх үйл явцыг г өргөжүүлж, боловсронгуй болгох. Жишээ нь АНУ-ын IRS-ийн туршлагаар аж ахуйн нэгж, байгууллага нь орлого иргэдэд шилжүүлсэн тохиолдолд татвар суутгасан ч бай, суутгаагүй байсан ч аль алиныг татварын албад нэг бүрчлэн иргэдээр нь дэлгэрэнгүй тайлагнадаг аргыг хэрэгжүүлэх. Тиймээс аж ахуйн нэгж, байгууллага татварын суутгал хийгээгүй иргэдэд олгосон орлогын мэдээллийг иргэн бүрээр татварын албанд ирүүлж, түүнийг мэдээллийн системд хянан боловсруулж, татвар төлөгчийг олж илрүүлэн, татварт хамруулах боломжтой болох юм.

3.2.4 Одоо өрдөгдөж буй ХХОАТХ-ийн аргачлал, журмыг өөрчлөн боловсруулж, заавар, зөвлөмжийн хэлбэрээр шинэчлэн найруулах, татварын

тайлангийн маягтуудыг татвар өлөгчдөд аль болох ойлгомжтой, энгийн хэлбэр рүү хялбаршуулан зохиох

- 3.2.5 Татварын хөнгөлөлт чөлөөлөлт эдлүүлэн, буцаан олголт олгох стратегийн чанартай үйл ажиллагааг татварын алба өөрөө хөнгөн шуурхай гардан гүйцэтгэж, татвар өлөгчдийн сэтгэл үйд эерэг нөлөө үзүүлэх, татварын албанд итгэх итгэлийг бий болгох, бэхжүүлэх
- 3.2.6 Хувь хүний орлогын татвар өлөгчийн е-бүртгэлт, е-тайлан, е-төлөлт, е-үйлчилгээ авах мэдээллийн технологийн нөхцлийг бүрдүүлэх, ХХАОТ-ын мэдээллийн баазын бүтэц, агуулгыг бүхэлд нь шинэчлэн сайжруулах
- 3.2.7 Хувь хүний орлогын албан татварын тасгийн ажилтнуудыг (татварын улсын байцаагч, хураагч, орон тооны бус байцаагч) зохион байгуулалттай сургалтанд хамруулж, хариуцлага тооцох, урамшуулах системд хамруулах, ажил, албан тушаалын өөрчлөлт, өсөлтийн ил тод төлөвлөлт, ажлын гүйцэтгэлийг дүгнэх үзүүлэлтийг боловсронгуй болгох зэрэгний хөгжлийн асуудалд цогцоор нь зөв зохистой хандах
- 3.2.8 Татвар өөрөө өөрөө тодорхойлох системийн үед иргэдийн төрдөө итгэх итгэл, татварын хууль дүрэм тэгш шударга байх явдал нэн чухал байдаг. Иймээс иргэдийг албан татвар төлдөг болгох олон нийтийн төлөвшил, бүх нийтийн боловсролын сурталчилгаанд “Албан татвар төлөгч - Ард үмний төлөөллийн үлгэрлэл”-ийг ашиглах. Ингэхийн тулд Улсын их хурлын гишүүдэд өнгөрсөн оны болон ирэх оны орлого, татвараа ил тод зарлах, ингэснээр Үндсэн хуулинд заасан албан татвар төлөх иргэний журамт үүргээ биелүүлэх, төр, хууль, сонгогч түмнээ дээдэлсэн ёс суртахууны өндөр үнэлэмжтэй, шударга байж, үүгээрээ улс орон, олон түмэнд нийгмийн үлгэр жишээ иргэн байх жишгийг (standard) авчрах талаар уриалсан албан захидал илгээх, энэ үйл ажиллагаанд тэдний мэдүүлсэн 2008, 2009 оны жөрөнгө орлогын мэдүүлгийг ашиглах, тэднийг хянах боломжтой болох
- 3.2.9 Манай улсад татвар төлөх нэгж ерхээр биш хувь хүн байдаг нь татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг ерхийн гишүүн бүрд давхар дуулан эдүүлэх боломж байгааг хаах. Татвар төлөгч иргэний татварын программд сургалтын зардал төлсөн хүүхдийн регистр, байр, орон сууцны үйлчилгээний дугаар оруулж давхардлаас сэргийлэх, үүнчлэн хуульд тодорхойгүй байгаа орон сууцны барилгын хамаарал, байнгын амьдрах зорилгоор хот суурин газраас зайдуу газар орон сууц барьсан тохиолдолд оруулах эсэх, анх удаа худалдан авсан өндөр үнэтэй орон байрны зардлыг гэр бүлийн эхнэр нөхөр 30, 30 сая төгрөгөөр татварын чөлөөлөлт эдэлж болох эсэх, суралцаж байх хугацаандаа гэдэг заалтад ажиллаж байх хугацаандаа суралцаж буй иргэд хамаарах эсэх асуудлуудыг тодруулах зорилгоор Дээд шүүхийн тайлбар гаргуулах
- 3.2.10 Хувь хүний орлогын албан татвар төлөгч иргэнийг татварын хяналт шалгалтад хамруулах ажлыг өргөтгөх. Ингэснээр татвар төлөгч иргэн татварт хамрагдахгүй явдал өргөн дэлгэр байгаатай холбогдуулан орлого, татвар алдах эрсдэл өндөр байгаа хэсэгт татварын шалгалт хийж, татварын хяналт байдгийг мэдрүүлэх. Иргэн хүн ч гэсэн татварын шалгалтад хамрагддаг гэдгийг мэддэг байх нь иргэд татвараа илүү үнэн зөв тайлагнах, төлөх магадлалтай болгодог сайн талтай гэж үзэж байна.

